

БАТЛАВ
 ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
 БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ЁСЗҮЙ ДЭД
 ХОРООНЫ ДАРГА
 Д.ТӨМӨРБААТАР

2026 оны 02 сарын 24-ний өдөр

БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2026 ОНЫ ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажил	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хариуцах албан хаагч
Нэг. Удирдлага зохион байгуулалт				
1.1	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг чадавхжуулахтай холбогдох зардлын асуудлыг шийдвэрлэх	Тухай бүр	Шийдвэрлэгдсэн зардал	Газрын дарга, ерөнхий нягтлан бодогч
Хоёр. Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх				
2.1	Байгууллагын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах	Улирал бүр	Сургалтын тоо -4, Хамрагдсан албан хаагчдын тоо	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд
2.2	Шинээр ажилд орсон албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ажлын байранд дагаж мөрдөх хэм хэмжээ, дотоод журмын ёс зүйтэй холбоотой заалтуудыг албан хаагчдад танилцуулах, баталгаажуулах	Тухай бүр	Танилцсан албан хаагчдын тоо	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд
2.3	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн штрок, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ /фэйсбүүк, твиттер, инстаграм, youtube суваг/, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх	Жилдээ	Түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо	Ёс зүйн дэд хороо
2.4	Байгууллагын албан хаагчдын ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээг баталсан аргачлалын дагуу хийж, эрсдэл бууруулах хариу арга хэмжээг авах	Жилдээ	Эрсдлийг тооцож, хариу арга хэмжээ авсан байдал	Ёс зүйн дэд хороо
2.5	Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлтэй гэж үнэлэгдсэн албан тушаал эрхэлдэг албан хаагчаар Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргуулж, хүлээн авах	Жилдээ	Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлтэй гэж үнэлэгдсэн албан тушаал эрхэлдэг албан хаагчдын тоогоор	Ёс зүйн дэд хороо
Гурав.Зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх				

3.1	Албан хаагчдын сахилга, ёс зүйтэй холбоотой ирсэн гомдлыг хэлэлцэж шийдвэрлэх, дүгнэлт гаргах, хүргүүлэх	Тухай бүр	Шийдвэрлэлтийн хувь	Ёс зүйн дэд хороо
3.2	Байгууллага, нэгж дотор гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөл, эрсдлийг тодорхойлж, зөвлөмж чиглэлийг хүргүүлэх	Тухай бүр	Хүргүүлсэн зөвлөмжийн тоо	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд
Дөрөв. Мэдээллэх тайлагнах				
4.1	Ёс зүйн зөрчил, холбогдох гомдол, мэдээлэл, шийдвэрлэлт, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын талаарх мэдээлэл, үйл ажиллагааны тайланг цахим систем болон байгууллагын цахим хуудсанд байршуулах	Тухай бүр	Оруулсан мэдээллийн тоо	Нарийн бичгийн дарга
4.2	Албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбогдох тайлан, мэдээг хүргүүлэх	Улирал бүр	Хүргүүлсэн тайлан, мэдээний тоо	Ёс зүйн дэд хороо
4.3	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайланг Ёс зүйн хороонд хүргүүлэх	Дараа оны 1 дүгээр сарын 05-ны дотор	Тайлан хүргэгдсэн байна.	Ёс зүйн дэд хороо

-оо0оо-